ОЛОН УЛСЫН

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ ӨДӨР

Орон нутагтаа хийсэн үйлдлээрээ
эх дэлхийдээ эерэг нөлөө үзүүлье.



ХУРГАТАЙ ХАЙРХАН

INTERNATIONAL DAY FOR BIODIVERSITY 2026
Acting locally for global impact

НҮБ-с жил бүрийн 5-р сарын 22-ний өдрийг **Биологийн олон янз байдлыг хамгаалах олон улсын өдөр** болгон зарласан байдаг.

Энэ өдрийг дэлхий нийтээрээ экосистемийн тэнцвэрт байдал, амьтан, ургамлын төрөл зүйлийг хадгалах, хамгаалах тэдгээрийн ач холбогдлыг сурталчлах зорилгоор тэмдэглэн өнгөрүүлдэг байна.

Энэ жилийн тухайд **"Орон нутагтаа хийсэн үйлдлээрээ эх дэлхийдээ эерэг нөлөө үзүүлье"** уриатай тус өдрийг тэмдэглэж байна.



ХУРГАТАЙ ХАЙРХАН

"Хургатай хайрхан" ХХК нь "Овоо" төслийг хэрэгжүүлэхдээ Биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага түвшин байлгах, дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана.



ХУРГАТАЙ ХАЙРХАН

"Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах" гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээ юм.”

"Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль"-н 3.1.11 дэх заалт.

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь хариуцлагатай уул уурхай болон тогтвортой хөгжлийн гол тулгуур болдог байна.

